

МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
СОРИЛТ, БЭРХШЭЭЛ

М.Дэлгэржаргал*

*БНХАУ-ын Ши-Ань Жиаотун Их Сургуулийн докторант

Түлхүүр үгс: сэтгүүл зүй, нийгмийн сүлжээ, хэвлэлийн эрх чөлөө, цензур, чөлөөт хэвлэл, ёс зүй

Монголын үндэсний сэтгүүл зүйн түүх нь Монгол Улсын орчин цагийн түүхтэй салшгүй холбоотой. Монгол оронд 1911 онд Үндэсний хувьсгал, 1921 онд Ардын хувьсгал, 1990 онд Ардчилсан хувьсгал өрнөхөд сэтгүүл зүй чухал үүрэг гүйцэтгэж, өөрийн хувь нэмрээ оруулж ирснийг онцлон тэмдэглэх ёстой.

"Шинэ толь хэмээх бичиг" сонин 1913 онд хэвлэгдсэнээр Монголын үндэсний сэтгүүл зүйн түүх эхэлж, өөрийн хөгжлийн хүнд хэцүү замыг туулсан юм. Монголын сэтгүүл зүй хөгжлийнхөө зуу гаруй жилийн ихэнх хугацаанд үзэл суртлын цагдан хяналт, нэг намын захиргаадалтын дор байж, бүхэлдээ "коммунист сэтгүүл зүй"-н дэгийг хатуу мөрдөж байсан. (Б.Галаарид 2018) 1990 онд Монгол Улс ардчилсан, чөлөөт нийгэмд шилжсэнээс хойш "Чөлөөт хэвлэл", хэвлэлийн эрх чөлөө хэрэгжих нөхцөл бүрдэж, төрөөс аливаа хэвлэл мэдээлэлд цензур тогтоохыг хуулиар хориглосноор бие даасан, хараат бус хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүй хөгжиж эхэлсэн.

Өнөөдөр Монгол Улсад бие даасан, хараат бус хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүй улам бүр гүнзгийрэн хөгжиж, 451 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байна. Мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, цахим сүлжээнд гарсан хувьсалтай холбоотойгоор 2000-аад оны эхэн үеэс Монголд цахим мэдээллийн хэрэгсэл идэвхтэй хөгжиж эхэлсэн. Мэдээ мэдээллийн цахим хуудаснууд, мөн Фейсбүүк, Твиттер зэрэг нийгмийн сүлжээний платформууд нэвтэрч, монголчуудын мэдээлэл, харилцааны гол эх сурвалж боллоо. Түүнчлэн, хууль тогтоох байгууллага болох Улсын Их Хурал, Засгийн газар ч нийгмийн сүлжээнд албан хаягуудыг нээж, түүгээрээ дамжуулан мэдээ мэдээлэл хүргэж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өрсөлдөөн нэмэгдэж, шинэ мэдээ, мэдээллийг шуурхай олж, аль болох олон хэрэглэгчид түгээх нь сэтгүүл зүйн гол зорилго болжээ. Гэвч сэтгүүл зүйн салбарыг бэхжүүлэх, мэргэжлийн, хараат бус, бие даасан, ёс зүйтэй сэтгүүл зүйд шилжих, шинэ чиг хандлага, арга хэлбэрийг бий болгох явдал чухлаар тавигдаж байна.

Судлагдсан байдлын тойм: Монголын хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн хөгжлийн өнөөгийн байдал, чиг

хандлагыг тодорхойлох судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг олон судлаач, сэтгүүлчид судалж иржээ. Уг судалгааны ажлаар хэвлэл мэдээллийн хууль эрх зүйн орчин, өнөөгийн байдлыг тодорхойлж, хөгжлийн зарим асуудлыг тухайлан судалж, дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Монгол Улсад дээд боловсролтой сэтгүүлч боловсон хүчнийг бэлтгэх ажил 1960-аад оноос эхэлсэн бөгөөд 1995 онд МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэргэд Сэтгүүл зүйгээр докторын зэрэг хамгаалах мэргэжсэн зөвлөл байгуулагдсан нь сэтгүүлчдийг докторын түвшинд бэлтгэж, сэтгүүл зүйн судалгааг гүнзгийрүүлэхэд хувь нэмрээ оруулсан гэж үзэх үндэслэлтэй. Сэтгүүл зүйн түүх, онол, тулгамдсан асуудал, хөгжлийн чиг хандлагын талаар судлаачид тал бүрээс хөндөн судалсан байдаг. Тухайлбал, доктор Г.Дэлэгийн “Тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” (Г.Дэлэг 1965) бүтээл нь Монголын хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн түүхийг судлахад үлэмж хувь нэмэр оруулсан бүтээл бөгөөд тогтмол хэвлэлийн үүсэл, хөгжлийн үеийг цогцоор нь анхлан судалснаараа онцлог. Түүнчлэн, Т.Баасансүрэн (Т.Баасансүрэн 2009), С.Жаргал (С.Жаргал 2002), Ю.Эрдэнэтуяа (Ю.Эрдэнэтуяа 1996), Л.Норовсүрэн (Л.Норовсүрэн 2001), М.Зулькафиль (М.Зулькафиль 2021) нарын бүтээлүүд болон сэтгүүл зүйн докторын зэрэг горилсон судалгааны ажлуудад Монголын сэтгүүл зүйн өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, сорилтуудын талаар тусгасан байдаг.

М.Зулькафиль Монголын сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлага: түүх, онол практикийн асуудлуудын талаар

судалгаандаа 1990 оноос эхлэн чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл оршин тогтнохыг төрөөс хүлээн зөвшөөрсөн боловч гурван гол асуудал болох санхүүгийн нөхцөл байдал, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдал нь хуулийн хүрээнд баталгаажуулаагүй, төр засгийн хэвлэл мэдээллийн монопол эрхээр дамжуулан чөлөөт хэвлэлд дарамт шахалт үзүүлэхийг шийдвэрлээгүй явдал гэдгийг тодотгосон.

Б.Галаарид, Монголын ардчилсан чөлөөт сэтгүүл зүй буюу чөлөөт хэвлэлийн үүсэл хөгжил, түүний үечлэл, ололт амжилт, тулгамдсан асуудал, нийгмийн хөгжил дэх үүрэг оролцоо, чөлөөт хэвлэлийн тухай үзэл онол Монголд төлөвшин бий болсон онцлог, Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөний байдал зэргийг 1980 оны сүүл үеэс өнөөг хүртэл сонины баримтад тулгуурлан судалсан.

Т.Батзориг, хэвлэлийн хараат бус байдлын хөгжлийн асуудал, эрх зүйн зохицуулалт, Редакцын хараат бус байдлын тогтсон үзэл баримтлал, олон улсад чөлөөт хэвлэлийн индексийг тогтоодог нарийн шалгуур үзүүлэлтүүдийг жишиг болгон судалж өнөөгийн Монголын хэвлэл мэдээллийн салбарын хараат бус байдлын түвшнийг тодорхойлсон.

Ш.Үнэнтөгс Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал, онцлог шинж судалгаагаа Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчны хүрээнд авч үзсэн байна.

Түүнчлэн гадаад хэл дээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл ч цөөнгүй байгаагаас Б.Наранбаатар "Освещение глобальных проблем современности в СМИ Монголии", М.Зулькафиль, З.Серик "The features and major issues of the development of

mongolian journalism in the age of globalization”, М.Мөнхмандах, Поул Эрик Нильсен “The Mongolian Media Landscape” зэргийг дурдаж болно. Судлаач М.Зулькафиль, З.Серик нар Монголын сэтгүүл зүй либертари сэтгүүл зүйгээс хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл зүй рүү тодорхой алхам хийж эхэлж буй ч шийдэгдээгүй асуудлууд байгааг дурдан, хэвлэл мэдээллийн хэрэгсэл тооноос чанарт шилжихийн тулд тодорхой бодлого явуулж, зоригтой алхам хийх хэрэгтэй байна гэж үзсэн нь (М.Зулькафиль, З.Серик, 2018) өнөөгийн бодит нөхцөл байдалтай нийцдэг.

Хэвлэл мэдээллийн салбарын сүүлийн үеийн чиг хандлагатай танилцах, олон улс орны эрдэмтдийн хамтын ажиллагааны сүлжээ үүсгэх, арга туршлага солилцох “Даяаршлын үеийн хэвлэл мэдээлэл ба олон нийтийн харилцаа” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим, АТГ хамтран анх удаа зохион байгуулж, өнөөгийн хэвлэл мэдээллийн орчны талаар хөндөн ярилцсан нь сэтгүүл зүйн өнөөгийн байдлыг тодорхойлоход олон улсын эрдэмтдийг татан оролцуулж, судлаачдыг Монголын сэтгүүл зүйд анхаарал хандуулах боломж олгосон томоохон алхам болсон.

Судалгааны зорилт:

- Хэвлэл мэдээллийн хууль эрх зүйн зохицуулалт, сэтгүүл зүйн өнөөгийн байдлыг тоймлон дүн шинжилгээ хийх
- Сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох
- Сэтгүүл зүйн өнөөгийн байдал, цаашдын хөгжилд ямар сорилт бэрхшээл тулгарч буйг гаргах

- Энэ төрлийн судалгааг шинэ эх хэрэглэгдэхүүнээр баяжуулах, судалгаа шинжилгээний шинэ бааз суурийг өргөхөд судалгааны зорилго оршино.

Дэвшүүлсэн таамаглал: Шинэ медиа хөгжиж, интернэт, олон нийтийн сүлжээний хэрэглэгчид нэмэгдэхийн хэрээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэднээс ялгарах, техник, технологийн шинэчлэл хийх, шинэчлэл хийхийн тулд медиа менежментийг хөгжүүлж, орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах замаар төрийн байгууллага, хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцааг тодорхой болгох, сэтгүүлчийн ёс зүйг төлөвшүүлэх шаардлагатай.

Материал, арга зүй: Өгүүлэл нь үйл явдлын хөгжлийн үйл явцыг одоо байгаа өгөгдлөөс цуглуулж, тайлбарлаж, дүн шинжилгээ хийж, хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг нэгтгэн харьцуулах замаар асуудлыг диалектик материализм, түүхэн материализмын өнцгөөс тодорхойлохыг зорьсон. Монголын сэтгүүл зүйн хөгжлийн тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх, түүнчлэн индуктив аргууд, харьцуулсан шинжилгээний аргуудыг ашиглав. Судалгааны аргын үндэс нь шинжлэх ухааны ерөнхий ба тусгай танин мэдэхүйн аргууд, уран зохиолын судалгааны аргууд, түүх судлал, системчлэл, загварчлал, харьцуулалт, логик болон бусад судалгааны аргууд гэх мэт өгөгдөлд дүн шинжилгээ хийх аргууд юм. Өмнөх эрдэмтдийн диссертаци, эрдэм шинжилгээний өгүүллийг авч үзсэнээс гадна Монголын Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаа, Максима консалтинг ХХК-ийн тайлангууд, Хэвлэл мэдээллийн эзэмшлийн талаарх тайлан болон интернэт хэрэглэгчдийн тоо, нийгмийн

сүлжээн дэх бүртгэлтэй Монгол хэрэглэгчдийн тоо гэх мэт интернэтэд суурилсан тоон дата мэдээллүүдийг ашигласан болно.

Үр дүн: Монголын сэтгүүл зүйн салбарын өнөөгийн байдал, эрх зүйн орчин

Монгол Улсад 1990-ээд оноос бие даасан, хараат бус хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүй хөгжих үндэс суурь тавигдаж, хөгжлийн тодорхой хугацааг туулсан ч өнөөдөр сэтгүүл

зүйн салбар өөрчлөлт, шинэчлэлийн үе дээрээ явж байна. Монголын хэвлэлийн хүрээлэнгээс 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр гаргасан статистик мэдээллээс үзвэл, 2022 оны байдлаар 188 онлайн медиа, 115 телевизийн суваг, 59 сонин, 43 сэтгүүл, 46 радио үйл ажиллагаа явуулж Монголын 3.5 сая гаруй хүн амд нийтлэл, нэвтрүүлгээ хүргэж байна.



График 1. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, 1999-2022.

Эх сурвалж: Монголын Хэвлэл мэдээлэл Өнөөдөр, Хэвлэлийн хүрээлэн 2023 он.

Дээрх судалгаанаас үзэхэд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо 2012 он хүртэл нэмэгдсэн ч аажмаар буурч буй дүр зураг ажиглагдаж байна. Үүний дотор сонин, сэтгүүлийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол буурч байсан бөгөөд сүүлийн жилүүдэд телевизийн тоо ч буурсан байна. (Хэвлэлийн хүрээлэн, 2023)

Өнөөдөр интернэт хэрэглэгчийн тоо улам бүр хурдацтай өсөн нэмэгдэхийн хэрээр уламжлалт хэвлэл мэдээллээс илүүтэйгээр онлайн медиагаас мэдээлэл авах нь түгээмэл болжээ. Иргэдийн олон нийтийн сүлжээ ашиглалт маш өндөр болсныг “Meta” компаниас гаргасан “The Inclusive internet index 2023” жагсаалтад Монгол Улс дэлхийн

хэмжээнд 62-т, Азийн 22 орноос тавдугаарт эрэмбэлэгдсэн явдал харуулж байна. (The Inclusive Internet Index, 2023) Тус жагсаалтад хамгийн өндөр хэрэглээтэй нийгмийн сүлжээний платформ нь Фейсбүүк, Инстаграм, Твиттер байсан бөгөөд Монгол дахь Фейсбүүк хэрэглэгчид 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 2974000 (<https://social-cdn.napoleoncat.com> 2023), Инстаграм хэрэглэгч 1083300 хүн байгаа нь нийт хүн амын 32.5 хувь бөгөөд хэрэглэгчдийн ихэнх нь эмэгтэйчүүд, насны бүлгийн хувьд 18-24 насныхан юм. Твиттер платформыг 131 500 хэрэглэгч ашиглаж байна. (<https://dataportal.com/reports/digital-2022-Mongolia> 2022)



График 2. Олон нийтийн сүлжээний хэрэглэгчид 2023
Эх сурвалж: <https://social-cdn.napoleoncat.com/i/2023/09/>

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон төрийн байгууллага, бизнесийн байгууллагууд ч фейсбүүкт албан хуудсыг нээн, үйл ажиллагаагаа танилцуулж, мэдээллээ тогтмол хуваалцдаг. Тухайн хуудсыг дагасан дагагчийн тоогоор олон хүнд нэгэн зэрэг хүрэх боломж нэмэгддэг учраас олон нийтийн сүлжээн дэх дагагчийн тоо ч улам бүр үнэ цэнтэй болжээ. Монгол Улсын хэмжээнд хамгийн олон дагагчтай хуудас болох Монгол телевизийн хуудас нэг сая 200 мянган дагагчтай. Зариг, Масс зэрэг мэдээллийн сайтуудын хуудсыг 1 сая 100 мянган хэрэглэгч дагадаг бөгөөд тэдний хуудсанд нэг мэдээлэл шинээр нэмэгдэхэд 1 сая гаруй хэрэглэгчид шууд хүрч, тэдгээр хэрэглэгчид нь өөрсдийн хуудсанд хуваалцвал тэдний найзуудад түгэх зэргээр маш хурдан хугацаанд олон хүнд нэгэн зэрэг хүрч байна. Харин төрийн байгууллагуудын хувьд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй харьцуулахад харьцангуй бага дагагчтай. Тэдгээрээс Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн хуудас 259 мянган дагагчтай нь хамгийн олон дагагчтай бол Монгол Улсын Засгийн газрын албан ёсны хуудсыг 203 мянган дагагч, Ерөнхийлөгчийн Тамгын газрын хуудсыг 173 мянган дагагч, Монгол Улсын Их Хурлын хуудсыг 96 мянган дагагч дагажээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны санхүүжилтээр хийгдсэн

“Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгаа 2021” (Иргэдийн интернэтийн суурь судалгаа, 2021) үндэсний судалгааны тайланд нэг өдөрт интернэт хэрэглэж буй дундаж хугацаа 7 цаг 13 минут хэмээсэн бол Максима консалтинг компанийн 2020 оны Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайланд “Телевиз үзэгчдийн дундаж хугацаа өдөрт 5 цаг 4 минут” (Телевиз үзэлтийн судалгаа, 2020) гэж тэмдэглэсэн. Үүнээс хэрэглэгч телевиз үзэхээс илүү урт хугацааг интернэт орчинд өнгөрүүлж байгаа нь харагддаг.

Сүүлийн үед өндөр технологийг нэвтрүүлж шинэ мэдээллийг шуурхай дамжуулахад шинэ хэвлэл мэдээллийн хэрэгслүүд их анхаарах болсон. Хүмүүс оройн, эсхүл цаг тутмын мэдээллийн хөтөлбөр хүлээхээсээ илүү фейсбүүк дэх сувгуудын шууд дамжуулалтыг үзэж мэдээлэл авах нь ихэссэн. Мөн чанартай эх сурвалж, мэргэжлийн сэтгүүл зүйг сонирхох нь нэмэгдэж байна. Гэтэл фейсбүүк зэрэг нийгмийн сүлжээнүүд дэх зарим хаягууд нь найдвартай эх сурвалж биш, худал мэдээлэл зориуд тарааж олон нийтийг төөрөгдүүлдэг. Иймээс хариуцлагатай, баталгаатай эх сурвалжийг бий болгох, мэдээллээ нягталж олон нийтэд хүргэдэг байх зэрэг нь сэтгүүл зүйн тулгамдсан асуудал хэвээр байна.

Монгол Улсын Их хурлаас 1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай

хуулийг баталсан нь Монголын сэтгүүл зүйн түүхэнд анхдагч бөгөөд хэвлэлийн эрх чөлөөний чухал баталгаа болсон юм. Тус хуульд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргах, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт буюу цензур тавихыг хориглож, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж буй зүйлийнхээ төлөө хариуцлагаа хүлээх, төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлгүй байх эрх зүйн үндсийг тавьсан (М.Дэлгэржаргал 2015). Олон нийтийн радио телевизийн тухай хуулийг 2005 онд баталж Монголын Үндэсний Радио Телевизийг олон нийтийн статустай болгон өөрчилсөн билээ. Түүнчлэн, 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баталснаар төрийн үйл ажиллагааны ил тод байдал, иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлсэн. Монгол Улсад Хэвлэл мэдээллийн салбарыг 2012 онд батлагдсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулиар стратегийн ач холбогдол бүхий гурван салбарын нэгд тооцох болсон. Ингэснээр гадаадын хөрөнгө оруулалтыг хэвлэл мэдээллийн салбарт хязгаарласан бөгөөд энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний ухамсар, ашиг сонирхолд нөлөөлөх улс орныг өргөн хүрээнд хамрах томоохон сүлжээ болохын хувьд үндэсний аюулгүй байдлын түвшинд тавигдаж буйн илрэл юм.

Өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааны хууль 2020 оноос хэрэгжиж эхэлсэн. Тус хуулиар төрөөс өргөн

нэвтрүүлгийн хөгжлийг дэмжих, радио телевизийн үндэсний бүтээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан байгуулж, өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгуудад дэмжлэг үзүүлж эхэлсэн.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)-д “Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана” гэж тодорхойлсон. Мөн Улсын Их хурлаас “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд (2020) “Хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ” хэмээн тусгажээ. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хараат бус байдал, бие даасан байдал, мэргэжлийн ёс зүйтэй сэтгүүл зүй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлэх тухай асуудал нь Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал болоод “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгалаа олсон нь сайн хэрэг боловч нөгөө талаар үүнийг хэрхэн хэрэгжүүлэх, ямар бодлого баримтлах зэрэг нь тодорхойгүй хэвээр байна.

Монгол Улсад өнөөг хүртэл хэвлэл мэдээллийн салбарыг хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлт байхгүй. Хэвлэл мэдээллийн салбар бусад салбар болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжилтийг

хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан нэгдмэл ашиг сонирхлыг багтаасан баримт бичиг ч алга. Энэ нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын орчин өнөөдөр бүрэн бүрдээгүйг илэрхийлдэг.

Сэтгүүл зүйн салбарын хөгжилд тулгарч буй сорилт, бэрхшээл. Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгээс явуулсан “Олон нийтийн санаа бодлын судалгаа” (О. н. судалгаа n.d.)-ны үр дүнгээр иргэд олон нийтийн мэдээллийн сүлжээгээр үзэл бодлоо илэрхийлснээр (2021 онд судалгаанд оролцогчдын 29%, 2022 онд 27%) Монгол Улсад шийдвэр гаргах үйл ажиллагаанд нөлөөлж чадна гэж ихэнх нь үзжээ. Түүнчлэн хэвлэл мэдээлэл нь институтийн хувьд төрийн болон төрийн бус бусад институтээс эерэг нэр хүндтэй байна. (2021 онд 69%, 2022 онд 62%)

Олон нийтийн дунд хэвлэл мэдээллийн нэр хүнд харьцангуй эерэг байгаа нь үүнийг улам бататгах, олон нийтийн сүлжээнээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл ялгарах мэргэжлийн ёс зүйн зарчмаа баримтлан ажиллах шаардлагатайг харуулдаг. Олон улсын практикт хэвлэл мэдээллийн байгууллага цахим орчинд ажиллахдаа өөрийгөө зохицуулах нэгдсэн удирдамж батлан мөрдөж

байна. (Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт судалгаа, 2019) Энэхүү удирдамж нь байгууллагын нэр хүндийг хамгаалах, иргэдийг төөрөгдүүлэхээс сэргийлэх, сэтгүүлч, сурвалжлагчийг гаднын эрсдэлээс хамгаалахад чиглэдэг учир хэвлэл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагаандаа нэвтрүүлбэл зохиох эерэг туршлага юм.

Ёс зүйтэй хэвлэл мэдээллийг төлөвшүүлэх: Монголын сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын салбарын төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллагын санаачилгаар 2015 онд “Хэвлэл мэдээллийн зөвлөл”-ийг байгуулсан. Тус байгууллагаас баталсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ууд дотроос “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулах, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ”, “Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ”, “Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурдана” гэх ёс зүйн зарчимтай холбоотой гомдол хамгийн түгээмэл байдаг. Энэ нь сэтгүүлчид, редакцууд мэдээллээ бататгах, нягтлах, эх сурвалжтай мэдээлэл бэлтгэх үндсэн гол үүргээ хангалттай биелүүлэхгүй байгааг харуулж байна. (Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2022)



График 3. Хэвлэл мэдээллийн зөвлөлд иргэдээс ирүүлсэн гомдол.
Эх сурвалж: <https://social-cdn.napoleoncat.com/i/2023/09/>.

Ёс зүйтэй хэвлэл мэдээллийг төлөвшүүлэхийн тулд редакцын бие даасан хараат бус байдал, түүнтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тогтоох шаардлагатай. Монгол Улсад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэдгээрийн эздийн ашиг сонирхлын тухай мэдээллийг албан ёсоор нийтэлж, ил тод болгодоггүй бөгөөд идэвхтэй эрэл хайгуул, судалгаа хийж байж зарим мэдээллийг олж авах боломжтой. Харилцаа холбооны зохицуулах хорооны журмаар хэвлэл мэдээллийн эзэд, удирдах бүрэлдэхүүнийг ил болгох ёстой боловч тэдгээрийн ашиг сонирхол бүхий этгээдийг, тухайлбал гэр бүлийн гишүүд, улс төрийн намын харьяалал зэргийг нийтэд ил тод зарлах заалт байхгүй. (Media ownership monitor Mongolia, 2016) Хэвлэл мэдээллийн эзэмшлийн хувьд төдийлөн нээлттэй бус байсаар байна. Монголын Хэвлэлийн хүрээлэнгийн сүүлийн судалгаагаар, хэвлэл мэдээллийн хэрэгслийн дийлэнх нь (74%) хувийн эзэмшилд байдаг байна. Хувийн хэвшлийн гэж байгаа боловч бизнесийн томоохон групп компаниуд, улс төрчдийн хамаарал бүхий хэвлэл мэдээллийн хэрэгсэл цөөнгүй бөгөөд жинхэнэ эзэмшигч, хөрөнгө оруулагчийг ил тод зарлах боломжгүй, хуулийн зохицуулалт ч байхгүй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эзэмшигч болон хөрөнгө оруулагчийнхаа талаар таагүй мэдээлэл, эсхүл сөрөг, эрх ашиг нь хөндөгдөх мэдээллийг нэвтрүүлэхгүй байхыг үгүйсгэхгүй.

Худал болон төөрөгдүүлсэн мэдээтэй тэмцэхийн тулд мэргэжлийн, ёс зүйтэй, хараат бус, бие даасан хэвлэл мэдээллийг бэхжүүлэх явдал чухлаар тавигдаж байна. Редакцууд өөрсдийн бодлогоо тодорхойлж, ёс зүйн хэм хэмжээгээ сахин ажиллахгүй

бол баталгаагүй эх сурвалжийн, худал ташаа мэдээллийг олон нийт үл тоож, тэдгээрт итгэх итгэл алдагдаж, өөр найдвартай баталгаатай эх сурвалж руу хандах болно.

Хүний эрхийн үндэсний комиссоос 2023 онд гаргасан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдал” XXII илтгэлд Хэвлэлийн эрх чөлөөний асуудлыг авч үзэж, яаж сайжруулах боломжтой талаар саналаа УИХ-д хүргүүлсэн. Тус илтгэлд Монголд хэвлэлийн эрх чөлөө хэрэгжиж байгаа ч хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод бус байдал, санхүүжилт хомс, сэтгүүлчдийн цалин хөлс, ажлын ачаалал зэрэг эдийн засаг, улс төрийн нөлөөлөл байсаар байгааг дурдаж, хараат бус байдлыг бэхжүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.

Хэвлэл мэдээллийн менежментийг хөгжүүлэх: Олон нийтийн сүлжээ нь хүмүүсийн мэдээлэл авах томоохон эх сурвалж болсон өнөө үед сэтгүүл зүйн үнэ цэнийг ойлгуулах, нэмэгдүүлэх, түүнчлэн хэвлэл мэдээллийг бизнес загвараар хөгжүүлэх, менежментийг сайжруулах асуудал чухлаар тавигдаж байна. Хэвлэл мэдээллийн бизнесийн талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй бус, нөгөө талаас, эзэмшигчид хэвлэлийн бизнесээс ашиг орлого олохоос илүү өөрсдийнхөө улс төрийн байр суурь, эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл болгох нь бий.

Өнөөдөр хэвлэл мэдээллийн байгууллагуудын гол орлогыг төрийн болон бизнесийн байгууллагын сурталчилгаанаас олсон орлого бүрдүүлж байна. Мөн хандив, захиалга, контентын төлбөр, төлбөрт үйлчилгээ зэр-

гээс санхүүждэг. Хэвлэл мэдээллийн салбарын зах зээлийн багтаамж хэдий хэмжээний мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх нь одоог хүртэл тодорхой бус байна. Нэгтгэсэн дүнгээр 50 орчим тэрбум төгрөг дунджаар 17 сая ам.доллар эргэлддэг гэх тойм тоо бий (<https://eguur.mn/202252/> n.d.) хэмээн “Эгүүр” мэдээллийн агентлаг 2021 оны 5 дугаар сарын 3-нд мэдээлжээ. Гэхдээ энэ нь тойм тоо бөгөөд хэвлэл мэдээллийн агентлагуудын санхүүжилт, орлогын мэдээлэл нууц хэвээр байна. Тиймээс энэ салбарт шинэ бизнес загварчлалыг нэвтрүүлэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч буй.

Хөндлөнгийн хараат бус судалгааны байгууллага болох Максима консалтинг ХХК-ийн зүгээс 2019 онд Монголын медиа зах зээлийн өнөөгийн байдлыг танилцуулсан. (Максима консалтинг, 2019) Тус илтгэлд олон улсын хэмжээнд арилжааны телевизийн орлого нь зар сурталчилгаа 85-90% (ивээн тэтгэлэг 2%), контентын борлуулалт 10-15%, томоохон төслийн хөрөнгө оруулалт байгаа бол Монгол Улсад зар сурталчилгаа 50% (үүнд бартер 20%), ивээн тэтгэлэг 15%, төлбөртэй, захиалгат мэдээ нэвтрүүлэг 10%, контентын борлуулалт 7%, эздийн татаас, бусад далд эх үүсвэр 18% байна. Түүнчлэн, тус байгууллага нь 2014 оноос эхлэн Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайланг танилцуулж, телевизийн зах зээлд ТОП 20 зар сурталчилгаа нийлүүлэгчийн жагсаалтыг нийтэлсэн. Зар сурталчилгаа нийлүүлэгч, нийлүүлэлтийн хэмжээгээр Монгол Улсын Засгийн газар нь 2014 онд 19 дүгээр байранд эрэмбэлэгдэж байсан бол 2018 оноос хойш тасралтгүй 1 дүгээрт эрэмбэлэгдэн,

тэргүүлжээ. Үүнээс харахад энэ салбарын зар сурталчилгааны гол бүрдүүлэгчийн нэг нь Засгийн газар болж байна. Мөн Нийслэлийн 2023 оны төсвийн жилд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Хэвлэл мэдээллийн зардалдаа 650 сая төгрөг буюу 208 мянга орчим ам.долларын төсөв зарцуулахаар тусгажээ. (<http://shd.mn/mn/images/shd/upload/2023-niislel-tosov-15-togtool.pdf> 2022) Энэ бол төрийн байгууллагууд мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчлахад ихээхэн анхаарч буйг илэрхийлж байна.

Хэвлэлийн хүрээлэнгээс хэвлэл мэдээллийн бизнесийн загвар, цахим шилжилттэй холбоотой сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлдэг. Тус хүрээлэнгийн судлаач Ж.Оюунцэцэг хэвлэл мэдээллийн бизнес төлбөртэй контент, орлого олох уламжлалт загвар, хандив (donation), захиалга (subscription), хөрөнгө босгох(crowdfunding), нийгмийн сүлжээний төлбөр (social paywall) зэргээр орлого олох олон төрлийн боломж бийг тэмдэглэжээ. (<https://pressins.meduim.com> 2022) Хэвлэл мэдээллийн салбарын менежментийг хөгжүүлэхэд дотоод эх үүсвэрээс гадна гаднын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах замаар чадавхжих, санхүүжилт босгох боломж бий. Хэвлэл мэдээллийн салбарт тогтвортой, бие даасан бизнес загвар нутагшуулах зорилгоор “Урагш алхъя” төслийг АНУ-ын Монгол Улс дахь ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр Сэтгүүл зүйн инноваци хөгжлийн үүр төв хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд хэвлэл мэдээллийн салбарт 100 сая төгрөгийн дэмжлэгээр 4 старт-ап төрүүлжээ.

Гаднын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулахыг хуулиар хориглосон учраас

хөрөнгө оруулалтыг дотоодоосоо татах нь чухал юм. Хэвлэл мэдээллийн салбарт анхны нээлттэй хувьцаат компани 2022 оны 4 дүгээр сард байгуулагдаж, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаагаа нээлттэй арилжаалж байна. Энэ стратеги нь бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудад шинэ жишиг тогтоох, олон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчтэй учраас нэг эзнээс хараат бус байж, редакцын бодлогод захирагдах, эзэд болон улс төрчдийн хөндлөнгийн нөлөөллийг буруулах, олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг, өгөөжөөс хүртэх боломжийг бүрдүүлэх зэрэг давуу талтай.

Төрийн байгууллагын хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцааг зохицуулах: Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хуулиар хориглосон ч төрийн байгууллагын дэргэдэх хэвлэл мэдээллийн алба нь хэт данхайж, нүсэр бүтэцтэй болж, мэдээллийн агентлагийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах боллоо. Түүнчлэн, тэдгээрийн хэвлэлийн алба нь өөрсдөө контент үйлдвэрлэн түүнийгээ олон нийтийн сүлжээнд байршуулах, бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд түгээх явдал их болсон. Үүний үр дүнд зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тухайн Хэвлэлийн албанаас ирүүлсэн контентыг түгээгч, дамжуулагч болж хувирч байна. Тухайлбал, Засгийн газрын Хэвлэлийн алба нь Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар болон өргөжиж, цахим мэдээллийн, сонин хэвлэлийн, контент боловсруулах, гадаад мэдээ сурталчилгааны зэрэг олон чиглэлийн хэлтэс, өргөн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуу-

лах болсон. Гэтэл Монголын мэдээллийн тэргүүлэх сайтын редакцууд болох Ньюс агентлаг 30, Gogo сайт 15, Ikon 16, Eguu 16, Zarig 24, Ergelt 18, iToim 9 ажилтантай, бусад нь үүнээс бага, цомхон орон тоотойгоор тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2020)-д “Чуулганы хуралдаан, УИХ-ын үйл ажиллагааг сурвалжлахтай холбогдсон журмыг УИХ-ын дарга батална”, Монгол Улсын Шүүхийн тухай хууль (2021)-д “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг Ерөнхий зөвлөл батална” гэж заасны дагуу баталсан журмын хүрээнд хэвлэл мэдээллийн ажилтнууд нь олон нийтэд мэдээлэл хүргэж байна. Гэсэн хэдий ч төрийн ихэнх байгууллагуудын олон нийтэд мэдээлэх өгөх үйл явц нь ойлгомжгүй, зарим тохиолдолд мэдээлэл өгөхөөс татгалзах явдал байсаар.

Харин Монголбанкны “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам” -д хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд төлбөртэй зар сурталчилгаа, нийтлэл, орчуулга, ярилцлагыг нийтлүүлэх асуудлыг тусгаж, Монголбанкны бодлогыг олон нийтэд үнэн зөв, шуурхай хүргэхэд идэвх зүтгэлтэй ажилласан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг шалгаруулж, урамшуулдаг. Энэ нь байгууллагын хэмжээнд хэвлэл мэдээлэлтэй харилцах бодлого, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтарч ажиллах чиглэл, арга хэлбэрээ оновчтой тодорхойлж зөв жишиг тогтоосон гэж үзэж болохоор байна.

Иймд төрийн байгууллагын дэргэдэх хэвлэлийн алба хэрхэн ажиллах талаарх үндэсний болон хөгжсөн орнуудын туршлагыг судалж, олон

улсын хэм хэмжээнд нийцсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Шинэ технологийг нэвтрүүлэх: Хэвлэл мэдээллийн салбарт гарч байгаа томоохон өөрчлөлтүүдийн нэг илрэл нь сэтгүүл зүйд виртуал бодит байдал, хиймэл оюун ухаан зэрэг шинэ технологийг ашиглаж эхэлсэн явдал юм. МҮОНТ 2023 оны 9 дүгээр сард хамгийн анхны виртуал хөтлөгчөө олон нийтэд танилцуулсан нь телевизийн салбарт анхдагч болсон бөгөөд цаашид ч технологийн дэвшилтэй уялдаж, үргэлжлэн хөгжих төлөвтэй байна.

Онлайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нийгмийн амьдралд улам бүр чухал үүрэг гүйцэтгэх болж буй үед илүү интерактив, өргөн агуулгыг бий болгохын тулд шинэ технологийг ашиглах хэрэгцээ шаардлага үүсэх нь зүйн хэрэг юм. Хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээ бичих, боловсруулалтад хиймэл оюун ухаан ашиглаж эхэлсэн. Тус алгоритмууд нь хэрэглэгчийн тохиргоог ойлгож, тохирсон агуулгыг хүргэхийн тулд их хэмжээний өгөгдөлд дүн шинжилгээ хийх чадвартай бөгөөд маш богино хугацаанд өргөн агуулгаар контекст боловсруулах давуу талтай.

Их өгөгдлийг оновчтой ашиглах, онлайн болон оффлайн захиалгыг хөгжүүлэх, зар сурталчилгааны автоматжуулалт, контентын менежментийг нэвтрүүлэх нь хэвлэл мэдээллийн хөгжилд чухал нөлөө үзүүлэхээр байна.

Монгол Улсад 5G сүлжээ нэвтрээд удаагүй байгаа бөгөөд цаашид хурдацтай нэвтрэх төлөвтэй байна. 5G сүлжээ нь илүү хурдан, найдвартай интернэт холболтыг бий болгож, хөдөлгөөнт төхөөрөмж дээр өндөр

чанартай медиа контентыг тасралтгүй дамжуулах боломж олгодог. Энэ технологи нь хэвлэл мэдээллийн хэрэглээ, түгээлтийн шинэ боломж болох нь тодорхой юм.

Дүгнэлт: Монголын сэтгүүл зүй хөгжлийн 110 жилийн хугацаанд нийгэм эдийн засгийн сорилтыг даван туулж, цаг үеийн шаардлага, шинжлэх ухаан, технологийн ололтоор баяжиж байна. Тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлагууд, шинэ медиа нь өөрийн өөрийн онцлогтойгоор хөгжиж, хөгжил, шилжилтийн замыг туулсаар байна. Өнөөдөр Монголын сэтгүүл зүй нь нийгмийн болон улс төрийн хамгийн хүчтэй институтүүдийн нэг. Тэд олон нийтийн санаа бодлыг бий болгох, сөрөг үзэгдлийг шүүмжлэх, үнэн, шударга ёсыг сэргээх, авлигын эсрэг шүгэл үлээх, хүмүүсийн сэтгэн бодох, шинэ байдлаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд маш их хувь нэмэр оруулах хүчирхэг платформ болжээ. Нөгөө талаар сэтгүүл зүй улам боловсронгуй мэргэжлийн болох, хүн төрөлхтний шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг ашиглах, иргэний сэтгүүл зүйгээс мэргэжлийн сэтгүүл зүй ялгарах шаардлага бодитоор тавигдаж байна.

Монгол Улсад Хэвлэл мэдээллийн салбарыг хөгжүүлэх цогц бодлого, үзэл баримтлал өнөөг хүртэл байхгүй байгаа явдал нь тулгамдсан асуудлын нэг болж байна. Хэвлэл мэдээллийн салбар хэрхэн ямар замаар хөгжих, хараат бус, бие даасан, мэргэжлийн сэтгүүл зүйг хөгжүүлэхийн тулд ямар бодлогоор урагшилж, урт, богино хугацаандаа аль түвшинд хүрэх талаарх шалгуур үзүүлэлтийг салбарын хэмжээнд хэлэлцэн нэгдсэн бодлого гаргах, хэвлэл

мэдээллийн байгууллага, редакц түүнд нийцүүлэн өөрийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Хууль эрх зүйн хүрээнд шийдэгдээгүй, тодорхой бус асуудлуудыг зохицуулах зохицуулалтыг бий болгох, хурдтай хөгжиж буй шинэ медиагийн эрин үед шинээр илрэн гарах харилцааг зохицуулахад хууль эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага ч урган гарч байна. Түүнчлэн, Засгийн газар, төрийн байгууллага, дэргэдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болж түүнийгээ бэхжүүлэх бус, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах бодлого, арга замаа тодорхойлох, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангах, ил тод байдлыг дээшлүүлэх, хууль ёсыг хэрэгжүүлэхэд хяналт тавих үүргээ идэвхтэй гүйцэтгэх хэрэгтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн зохицуулалтын асуудлыг цогцоор авч үзэж тодорхойлох, редакцын хараат бус байдлыг бэхжүүлэх, түүн дотроо хэвлэл мэдээллийн бие даасан хараат бус байх асуудлыг шийдвэрлэх, санхүүгийн хараат бус байдлаа сайжруулахын тулд шинэ менежментийг нэвтрүүлэх шаардлагатай болж байна.

Эшлэл

1. Г.Дэлэг. 1965. *Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл*. Улаанбаатар.
2. С.Жаргал. 2002. *Соёлын хөгжилд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг*. Улаанбаатар.
3. Б.Галаарид. 2018. *Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшил*. Улаанбаатар.

4. М.Зулькафиль. 2021. *Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд*. Улаанбаатар.
5. Ю.Эрдэнэтуяа. 1996. *Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал*. Улаанбаатар.
6. Л.Норовсүрэн. 2001. *Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм*. Улаанбаатар.
7. М.Зулькафиль, З.Серик. 2018. "The features and major issues of the development of mongolian journalism in the age of globalization". *Евразийский Союз Ученых* 49-54.
8. Т.Баасансүрэн. 2009. *Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь*. Улаанбаатар: Монцамэ.
9. М.Дэлгэржаргал. 2015. *Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх гэмт хэргийн эргүүгийн эрх зүйн асуудал*. Улаанбаатар.
10. Хэвлэл мэдээллийн зөвлөл. "Үйл ажиллагааны тайлан 2022." Улаанбаатар.
11. Олон нийтийн санаа бодлын судалгаа n.d. <https://www.uih.mn/>. <https://www.uih.mn/sudalгаа>.
12. Телевиз үзэлтийн судалгаа. 2020. <https://maxima.mn/newsmn>.
13. Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт судалгаа. 2019. [https://gic.mn/public/docs/publications/edited_Final_survey_result_social_media_regulation_191024-converted%20\(1\).pdf](https://gic.mn/public/docs/publications/edited_Final_survey_result_social_media_regulation_191024-converted%20(1).pdf).
14. Иргэдийн интернэтийн суурь судалгаа. 2021. <https://crc.gov.mn/>. https://crc.gov.mn/storage/busad/03_Survey%20report_MMCG_final-2021.pdf.
15. Хэвлэлийн хүрээлэн 2023. "Монголын Хэвлэл мэдээлэл Өнөөдөр." Улаанбаатар.
16. Commission, Communications Regulatory. 2021. 7 8. https://crc.gov.mn/storage/busad/03_Survey%20report_MMCG_final-2021.pdf

17. Нийслэлийн төсөв 2023. <http://shd.mn/mn/images/shd/upload/2023-niislel-tosov-15-togtool.pdf>.
18. Цахим Монгол судалгаа 2022. <https://dataportal.com/reports/digital-2022-Mongolia>.
19. Монголын сэтгүүл зүй яагаад гажуудав, бид хаашаа явах ёстой вэ <https://eguur.mn/202252/>.
<https://eguur.mn/202252/>.
20. The inclusive internet index. 2023. <https://social-cdn.napoleoncat.com>.
<https://social-cdn.napoleoncat.com/i/2023/09/>.
21. Economist impact <https://theinclusiveinternet.eiu.com/explore/countries/performance?category=affordability>. 10 12.
22. Media ownership monitor Mongolia 2016. <https://mongolia.mom-rsf.org/mn>.
4. М.Мөнхмандах, Поул Эрик Нильсен "The Mongolian Media Landscape"
5. Т.Батзориг "Монголын чөлөөт хэвлэлийн хараат бус байдлын судалгаа"
6. www.legalinfo.mn

Summary

Journalism in Mongolia has history of over 110 years of development. The country has transitioned to a democratic system and has fostered an independent media sector, yet this article identifies several persisting challenges.

In the context of new media development and the increasing popularity of internet and social networks, the media industry faces the imperative of differentiation and innovation. This article argues that the media sector needs to enhance its management capacity, achieve financial autonomy by diversifying its revenue sources, improve the legal framework, clarify the relations between government agencies and media outlets, and develop a code of journalistic ethics.

Keywords: journalism, social media, press freedom, censorship, free press, ethics.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. М.Зулькафиль Монголын сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлага: түүх, онол практикийн асуудлууд
2. Ш.Үнэнтөгс "Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал, онцлог шинж"
3. Б.Наранбаатар "Освещение глобальных проблем современности в СМИ Монголии". Москва. 2010.